| <b>2107</b>   | <b>Томилолт, зочны зардал</b>  | 3,161,800.00   | 3,158,000.00   | 3,800.00      | 99.88  |
| 210702        | Дотоод албан томилолт  | 3,161,800.00   | 3,158,000.00   | 3,800.00      | 99.88  |
| <b>2108</b>   | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>      | 9,762,700.00   | 8,714,018.00   | 1,048,682.00  | 89.26  |
| 210801        | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,565,000.00   | 6,561,050.00   | 1,003,950.00  | 86.73  |
| 210802        | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 250,000.00     | 250,000.00     | 00.00         | 100.00 |
| 210803        | Даатгалын үйлчилгээ  | 300,000.00     | 300,000.00     | 00.00         | 100.00 |
| 210804        | Тээврийн хэрэгслийн татвар   | 912,000.00     | 900,268.00     | 11,732.00     | 98.71  |
| 210805        | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 33,000.00      | 00.00          | 33,000.00     | 00.00  |
| 210807        | Газрын төлбөр  | 702,700.00     | 702,700.00     | 00.00         | 100.00 |
| <b>2109</b>   | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                               | 400,342,500.00 | 387,011,182.00 | 13,331,318.00 | 96.67  |
| 210901        | Бараа үйлчилгээний бусад зардал                                      | 399,600,000.00 | 386,268,682.00 | 13,331,318.00 | 96.66  |
| 210902        | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                                    | 742,500.00     | 742,500.00     | 00.00         | 100.00 |
| <b>213</b>    | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | 33,296,400.00  | 33,263,400.00  | 33,000.00     | 99.90  |
| <b>2132</b>   | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | 33,296,400.00  | 33,263,400.00  | 33,000.00     | 99.90  |
| 213207        | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж                  | 25,444,000.00  | 25,443,000.00  | 1,000.00      | 100.00 |
| 213209        | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал                              | 7,852,400.00   | 7,820,400.00   | 32,000.00     | 99.59  |
|               | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                | 991,929,900.00 | 949,147,142.94 | 42,782,757.06 | 95.69  |
| <b>1320</b>   | <b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>                                | 961,829,900.00 | 931,727,960.94 | 30,101,939.06 | 96.87  |
| 132001        | Орон нутгийн төсвөөс   | 961,829,900.00 | 931,727,960.94 | 30,101,939.06 | 96.87  |
| <b>120004</b> | <b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>                         | 30,100,000.00  | 17,419,182.00  | 12,680,818.00 | 57.87  |
| 1200041       | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих                            | 30,100,000.00  | 17,419,182.00  | 12,680,818.00 | 57.87  |
| <b>61</b>     | <b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>  | 1              | 1              |               |        |
| 610001        | Төсвийн байгууллага  | 1              | 1              |               |        |
| <b>62</b>     | <b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>  | 47             | 47             |               |        |
| 620001        | Удирдах ажилтан  | 1              | 1              |               |        |
| 620002        | Гүйцэтгэх ажилтан  | 39             | 39             |               |        |
| 620003        | Үйлчлэх ажилтан  | 6              | 6              |               |        |
| 620004        | Гэрээт ажилтан   | 1              | 1              |               |        |
| <b>65</b>     | <b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>   | <b>47</b>      | <b>47</b>      |               |        |
| 650001        | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)                                   | 37             | 37             |               |        |

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

|        |  |   |   |  |  |
|--------|--|---|---|--|--|
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 9 | 9 |  |  |
| 650010 | Гэрээт ажилтан                             | 1 | 1 |  |  |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код  | Үзүүлэлт   | Өмнөх он             | Гүйцэтгэл            |
|-------------|--|----------------------|----------------------|
|             | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>  |                      |                      |
| <b>I</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>   | <b>54,841,450.00</b> | <b>30,529,239.00</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>   | <b>54,841,450.00</b> | <b>30,529,239.00</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | <b>24,650,000.00</b> | <b>00.00</b>         |
| 210801      | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж                                       | 24,650,000.00        | 00.00                |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>   | 0.00                 | 30191450.00          |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал  | 00.00                | 30,191,450.00        |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>  | 30,191,450.00        | -                    |
| <b>2132</b> | <b>Бусад урсгал шилжүүлэг</b>  | 00.00                | 337,789.00           |
| <b>2133</b> | <b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>   | <b>30,191,450.00</b> | <b>00.00</b>         |
| 213405      | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг                            | 30,191,450.00        |                      |
| 213503      | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг   | 00.00                | 337,789.00           |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>  | 54,841,450.00        | 30,529,239.00        |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>   | 54,841,450.00        | 30,529,239.00        |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,000,000.00        |                      |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 44,841,450.00        | 30,529,239.00        |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл   | -                    | -                    |
|             | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл  | -                    | -                    |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь байгаль орчны чиглэлийн хууль тогтоомжийг харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, байгаль хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчин, аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, байгаль орчин, ногоон хөгжлийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлыг гүйцэтгэдэг аймгийн Засаг даргын харьяаны байгууллага юм.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/79 дүгээр захирамжаар Байгаль орчин, аялал жуулчлалын газрын бүтцийг 48 орон тоотойгоор баталсан бөгөөд 2022 онд байгууллагын дарга-1, ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн -6, байгаль хамгаалагч-26 бусад үйлчилгээний албан хаагчид -10 нийт 47 орон тоотой үйл ажиллагаа явуулсан бөгөөд нийт 990,641.9 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын зорилго зорилт нь Байгаль орчны чиглэлийн хууль тогтоомжийг харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх, байгаль хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль

орчин, аялал жуулчлалын мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх, байгаль орчин, ногоон хөгжлийн сургалт, судалгаа, сурталчилгааны ажлыг гүйцэтгэхэд оршино.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үгийг дарга Э.Ганзориг 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Мөнхнасан (2022.01.01-2022.06.15), Ж.Янжмаа (2022.06.15-2022.07.25), Л.Доржханд (2022.07.25-2022.12.31) нар зурж, нярваар Б.Хажидсүрэн ажиллажээ.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж эхэлсэн.
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор цалингийн шатлал өөрчлөгдсөн.
- Засгийн газрын 2022 оны 120 дугаар тогтоолоор албан томилолтын зардлын тариф өөрчлөгдсөн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баянхонгор аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны шилэн дансны үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын үйл ажиллагаандаа мөрддөг Баянхонгор аймгийн төсвийн байгууллага, төсөл сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэхэд мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг” нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,279,308.4 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 639,369.1 мянган төгрөгөөр буюу 99.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл   | Эцсийн үлдэгдэл    | Өөрчлөлт         |
|---|------------------|--------------------|------------------|
| Б   | 1                | 2                  | 3=2-1            |
| <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>                    | 195,744.6        | 446,601.1          | 250,856.4        |
| Мөнгөн хөрөнгө                                    | -                | -                  | -                |
| Авлага  | 77,366.4         | 5,939.5            | (71,426.9)       |
| Бараа материал                                    | 118,378.2        | 440,661.6          | 322,283.3        |
| <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                | 444,324.3        | 832,707.3          | 388,383.0        |
| Үндсэн хөрөнгө                                    | 625,603.9        | 1,064,014.7        | 438,410.7        |
| Хуримтлагдсан элэгдэл                             | (181,279.6)      | (231,307.3)        | (50,027.7)       |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>640,068.9</b> | <b>1,279,308.4</b> | <b>639,239.5</b> |
| Өр төлбөр   | 129.6            | -                  | 129.6            |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/               | 639,939.3        | 1,279,308.4        | 639,369.1        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>640,068.9</b> | <b>1,279,308.4</b> | <b>639,239.5</b> |

Дээрх хүснэгтээс харахад авлагын дансны үлдэгдэл 5,939.5 мянган төгрөг болж өмнөх оноос 71,426.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлага болох нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 30,191.5 мянга, “Би эйч энд ди” ХХК-иас гэрээний дагуу авах 44,835.0 мянга, ажилчидтай холбоотой 1,285.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулж тайлант онд “Даяар трейд” ХХК-ний хийж гүйцэтгэсэн “Шинэ суурьшлын бүсэд мод үржүүлгийн газар байгуулах” ажлыг хүлээлгэн өгөөгүй тул үлдэгдэл санхүүжилт 5,308.7 мянга, Монголын Цахилгаан холбоо ХХК-иас 7.2 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлт 123.1 мянга, ХХОАТ-ын илүү төлөлт 500.5 мянган төгрөгийг авлагаар тусгасантай тус тус холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 440,661.6 мянган төгрөг болж өмнөх оноос 322,283.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 282,397.1 мянга, аймгийн ОБГ-аас шилжүүлэн авсан 49.0 мянга, үндсэн хөрөнгө акталснаас буцааж орлого авсан 310.3 мянга, “Тэрбум мод” аяны хүрээнд уул уурхайн компаниас шинэ суурьшлын бүсийн ойжуулалтад олгосон 52,822.4 мянган төгрөг, 2022 оны авлагаар тусгасан 44,835.0 мянга, нийт 380,413.8 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэсэн, мөн байгууллагын даргын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн А/50 дугаар тушаалаар 4,317.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас өгсөн зөвлөмжийн дагуу 11,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэж, 42,813.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,064,014.7 мянган төгрөг болж 438,410.7 мянган төгрөгөөр өссөн нь Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал буюу төсвийн хөрөнгөөр 39,950.0 мянга, Аудитын зөвлөмжийн дагуу шилжүүлэн авсан 11,000.0 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 250,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий Виртуал студийн барилга, тавилга, тоног төхөөрөмж, БОАЖЯ-ны хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн 41,100.0 мянган төгрөгийн өртөг бүхий 48-88 БНН улсын дугаартай пургон автомашин, Орон нутгийн өмчийн газрын 2022.10.24-ны өдрийн А/246 тоот албан бичгийн дагуу бүртгэлд тусгагдаагүй байсан 3 газрыг үнэлж 358,600.0 мянган төгрөгөөр тус тус бүртгэсэн, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн

Хурлын 10 дугаар хуралдааны 10/43 дугаартай тогтоолоор тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 250,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий Виртуал студийн барилга, тавилга, тоног төхөөрөмжийг Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газарт балансаас балансад шилжүүлсэн, мөн 10/46 дугаар тогтоолоор 14 нэрийн 12,239.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассантай тус тус холбоотой байна.

Тайлант онд өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,279,308.4 мянган төгрөг болж 639,369.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 639,369.1 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, орон нутгийн төсвөөс 1,250,288.4 мянга, үйл ажиллагааны орлогоос 1000.0 мянга, нийт зардлыг 1,251,288.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 291,476.9 мянган төгрөгөөр бууруулж 959,811.5 мянган төгрөгөөр анх батлагдсан бөгөөд тайлант онд төсөвт нэг удаа тодотгол хийж орлогыг 31,100.0 мянга, зардлыг 3,140.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн нийт зардлыг 990,641.9 мянган төгрөг болгон баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 961,829.9 мянга, өөрийн орлогоос 30,100.0 мянга нийт 991,929.9 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 961,829.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлогоос 17,419.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 949,147.2 мянган төгрөгийг зарцуулж 41,574.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 949,147.2 мянган төгрөг буюу 95.8 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 41,574.5 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

(мянган төгрөгөөр)

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ                       | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү    | Биелэлт |
|-----|---|------------|-----------|----------|---------|
|     | 71413 Байгаль орчин, аялал жуулчлалын газар | 990,641.9  | 947,915.1 | 21,219.0 | 95.7    |
| 1   | 80101 Үндсэн үйл ажиллагааны зардал         | 481,521.3  | 459,388.7 | 624.8    | 95.4    |
| 2   | 80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал       | 1,085.0    | 723.0     | 362.0    | 66.6    |
| 3   | 80219 Харуул, хамгаалалтын зардал           | 6,480.0    | 5,838.0   | 642.0    | 90.1    |

**Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын  
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

|   |   |           |           |          |      |
|---|---|-----------|-----------|----------|------|
| 4 | 80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг             | 33,296.4  | 33,263.4  | 33.0     | 99.9 |
| 5 | 81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал | 399,600.0 | 386,268.7 | 13,331.3 | 96.7 |
| 6 | 80112 Нийтлэг йлчилгээ  | 68,659.2  | 62,433.3  | 6,225.9  | 90.9 |

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь 2021 онд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 30,191.5 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данс руу төвлөрүүлж уг санхүүжилтийг тайлант хугацааны авлагаар тусгасан байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн IX хуралдааны 9/24 дугаар тогтоолоор төсвийн байгууллагын өөрийн орлогыг 31,100.0 мянган төгрөгөөр батлуулж авлагыг үндсэн санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна.

Мөн иргэн Эрдэнэсайханаас нэмэлт санхүүжилтийн дансанд 337.8 мянган төгрөг тушаасныг зарцуулаагүй орон нутгийн орлогод төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Батчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цээням, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 448 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 876,575.1 мянган төгрөгийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 876,575.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 13,148.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 9,204.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд бусад хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 133 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд харилцагч байгууллагатай байгуулсан 6 гэрээний 127,695.7 мянга, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 541,826.4 мянган төгрөгийн 10 гүйлгээ, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 439,028.4 мянган төгрөгийн 26 гүйлгээ, хүний нөөц, өмч хөрөнгө, санхүүтэй холбоотой 71,531.1 мянган төгрөгийн 77 шийдвэрийн мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

Харин шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 452,732.7 мянган төгрөгийн 6 гүйлгээ, зарлагын 10,439.0 мянган төгрөгийн 1 гүйлгээг дутуу мэдээлсэн байна. Мөн гэрэл цахилгаан, цэвэр бохир ус нийлүүлэх гэрээнүүдийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах, цаашид зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэх.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 301,352.2 мянган төгрөгийн 11 алдаа зөрчил илэрснээс 44,835.0 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулж, 30,191.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 31,217.5 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 195,108.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгснийг 100 хувь хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт                      | Өмнөх аудитын үзүүлэлт |                  | Биелэлт   |                  |            |
|-------------------------------|------------------------|------------------|-----------|------------------|------------|
|                               | Тоо                    | Дүн              | Тоо       | Дүн              | Хувь       |
| Албан шаардлага               | 4                      | 31,217.5         | 4         | 31,217.5         | 100        |
| Төлбөрийн акт                 | 1                      | 30,191.5         | 1         | 30,191.5         | 100        |
| Зөвлөмж                       | 5                      | 195,108.2        | 5         | 195,108.2        | 100        |
| Санхүүгийн тайланд залруулсан | 1                      | 44,835.0         | 1         | 44,835.0         | 100        |
| <b>Нийт дүн</b>               | <b>11</b>              | <b>301,352.2</b> | <b>11</b> | <b>301,352.2</b> | <b>100</b> |

Тус байгууллагын 2022 оны 10 дугаар сарын 206-ны өдрийн 420 тоот албан бичгээр албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, 11 дүгээр сарын 10-ны өдрийн 435 тоот албан бичгээр төлбөрийн актын биелэлтийг ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

. Аудитаар нийт 11,308.6 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 750.0 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 750.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 10,168.6 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

5.1.1. Худалдан авах ажиллагааны АЗ сургалтын төлбөрт 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр 300.0 мянган төгрөгийг хичээл практикийн зардлаас зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн хэмнэлтийн тухай 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сургалтын зардалд зарцуулсан 300.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1.2. Сургалтын зардлаас 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр тус бүр нь 150.0 мянган төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг уран зургийн үнэнд 450.0 мянган төгрөгийг зарлагдаж шагналд зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зориулалт бусаар зарцуулсан 450.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

## **5.2 Албан шаардлага**

5.2.1. Газрын даргын 2022.03.07-ны өдрийн "Тэтгэмж олгох тухай" Б/29 дүгээр тушаалаар байгууллагын 13 эмэгтэй албан хаагчид нийт 390.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас олгосон байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн хэмнэлтийн тухай 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

## **5.2 Зөвлөмж**

5.3.1. Тус байгууллага нь тайлант хугацаанд сургалтын зардалд нийт 19,936.4 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд 6,348.6 мянган төгрөг буюу 31.8 хувийг хоол, цайны зардалд, 2,170.0 мянган төгрөг буюу 10.9 хувийг шагнал, өргөмжлөл, медаль, бэлэг дурсгалын зүйлд, 4,720.0 мянган төгрөг буюу 23.7 хувийг томилолтын зардалд, 5,192.8 мянган төгрөг буюу 26.1 хувийг бичиг хэргийн зардалд, 1,505.0 мянган төгрөг буюу 7.5 хувийг шатахууны зардалд тус тус зарцуулсан байна.

Өргөмжлөл, медаль, шагнал, хоолны зардалд нийт сургалтын зардлын 42.7 хувийг зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Цаашид сургалтын хоолны зардлыг гаргахгүй, бэлэг дурсгалын зүйл худалдан авсан зөрчлийн арилгаж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 дахь "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалтыг хэрэгжүүлэн сургалтыг цахимаар зохион байгуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| Зөрчлийн товч утга  | Нийт зөрчил |                 | Үүнээс        |              |                 |              |          |                 |                                      |                     |   |          |
|---|-------------|-----------------|---------------|--------------|-----------------|--------------|----------|-----------------|--------------------------------------|---------------------|---|----------|
|   |             |                 | Төлбөрийн акт |              | Албан шаардлага |              | Зөвлөмж  |                 | Хариуцлага тооцуулах албан шаардлага |                     | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал |          |
|   | Тоо         | Дүн             | Тоо           | Дүн          | Тоо             | Дүн          | Тоо      | Дүн             | Тоо                                  | Албан тушаалтны тоо | Тоо   | Дүн      |
| Газрын даргын 2022.03.07-ны өдрийн "Тэтгэмж олгох тухай" Б/29 дүгээр тушаалаар байгууллагын 13 эмэгтэй албан хаагчид тус бүр 30.0 мянга, нийт 390.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас олгосон байна. | 1           | 390.0           |               |              | 1               | 390.0        |          |                 |                                      |                     |   |          |
| Худалдан авах ажиллагааны АЗ сургалтын төлбөрт 2022.04.29-ний өдөр 300.0 мянган төгрөгийг зарцуулсан.   | 1           | 300.0           | 1             | 300.0        |                 |              |          |                 |                                      |                     |   |          |
| Өргөмжлөл, медаль, шагнал, хоолны зардалд нийт сургалтын зардлын 4,270.0 мянган төгрөг буюу 42.7 хувийг зарцуулсан байна.   | 1           | 10,168.6        |               |              |                 |              | 1        | 10,168.6        |                                      |                     |   |          |
| Сургалтын зардлаас 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдөр тус бүр нь 150.0 мянган төгрөгийн үнэ бүхий 3 ширхэг уран зургийн үнэнд 450.0 мянган төгрөгийг зарлагдаж шагналд зарцуулсан байна.                                     | 1           | 450.0           | 1             | 450.0        |                 |              |          |                 |                                      |                     |   |          |
| <b>Нийт дүн</b>   | <b>4</b>    | <b>11,308.6</b> | <b>2</b>      | <b>750.0</b> | <b>1</b>        | <b>390.0</b> | <b>1</b> | <b>10,168.6</b> | <b>0</b>                             | <b>0</b>            | <b>0</b>  | <b>0</b> |